



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/289

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “Сум хөгжүүлэх сан”-гийн улсын үзлэгийг 2019 оны 5 дугаар сарын 6-наас 20-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Улсын үзлэгийг сумдад зохион байгуулахад шаардагдах шатахууны зардал 752720 (долоон зуун тавин хоёр мянга долоон зуун хорь) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.
3. Улсын үзлэгийг үр дүнтэй зохион байгуулж, тайланг хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг ажлын хэсэг (Ц.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100683

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дүгээр сарын 03-ны өдрийн 1289 дугаар
захирамжийн хавсралт

“СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч – Ц.Ганболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: -Г.Баясгалан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

- С.Цэдэнбалжир (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

- Ц.Навчаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

-Т.Эрдэнэсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

-Т.Нямсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

-Н.Лхамдолгор (Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагч)

-Ц.Ариунаа (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны дарга)

-С.Сэдэд (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын ахлах мэргэжилтэн)

-Д.Бямбадулам (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

-Д.Нансалмаа (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга – Н.Дулам (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)